

ОРОН НУТГИЙН ӨРХИЙН ХОГНЫ БҮТЦИЙН СУДАЛГАА

БУЛГАН АЙМГИЙН
ХИШИГ-ӨНДӨР СУМ
2019 - 2020



ТАНИЛЦУУЛГА, ЗОРИЛГО

Монгол улс даяар, тэр дундаа Хишиг-Өндөр сум мэт орон нутгийн хогны бүтцийн тухай мэдээ маш дутмаг. Хогны менежментийн төслийнхөө хүрээнд Экосум ТББ-аас Хишиг-Өндөр сумын өрхүүдийг хамруулан 2019 оны 7 сард, 2020 оны 1 сард хогны

бүтцийн судалгааг хоёр удаа Азийн сангийн дэмжлэгтэйгээр хийлээ. Тус судалгааны зорилго нь орон нутагт амьдарч буй дундаж өрхөөс өвөл, зуны улиралд хэр хэмжээний хог гардаг, гарч буй хогны бүтцийг нарийвчлан гаргах юм.

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ


Хоёр судалгаанд хоёуланд нь Хишиг-Өндөр сумын төвийн 376 өрхийн 10 орчим хувийн төлөөлөл болох (өвөл 35, зун 36 өрх) хамрагдсан. Судалгаанд оролцсон өрхүүд 7 хоногийн турш үүсч буй нийт хогоо цуглуулаад 14 төрлөөр ангилах зааварчилгааг авсан. Судалгааны хугацаа дуусахад Экосум бүх хогийг хүлээж аваад нэг бүрчлэн жинлэв. Цуглуулсан мэдээллийг

нягтлан дараах үр дүнг дүгнэн гаргалаа. Судалгаанд оролцсон өрх бүрээс тэдний хогны бүтэц, хэмжээ болон мэдээллийг нягтлахад нөлөөлж болохгүйц (орон байрны төрөл, өрхийн гишүүдийн бүтэц, дундаж орлого, халаалт, хоол бэлтгэх систем, өрхийн дэргэдэх мэргэжлийн үйл ажиллагаа гэх мэт) өгөгдлүүдийг багтаасан асуултуудтай асуулгыг мөн авсан болно.

ҮР ДҮН

ӨРХИЙН ЖИЛИЙН ХОГНЫ БҮТЭЦ ДУНДЖААР



→ % ЖИНГЭЭР



5 үндсэн төрлийн хог – үнс (40%), шил (15%), хүнс (14%), хуванцар (11%) болон хүүхдийн живх (8%) – өрхийн бүтэн жилийн хогны нийт 88%-ийг эзэлж байна. (жингээр)

ӨРХӨӨС ҮҮСЭХ ҮНСНИЙ ДУНДАЖ ХЭМЖЭЭ УЛИРЛААР



→ % ЖИНГЭЭР



Зунтай харьцуулахад өвөл гарах үнсний хэмжээ **10 дахин** их байна. Өвөл 4.3кг, зун 0.4кг. Тиймээс өрхөөс гарах нийт хогноос зуны улиралд **11%-ийг**, өвлийн улиралд **54%-ийг** үнс эзэлж байна.

ӨРХИЙН ХОГНЫ ДУНДАЖ БҮТЭЦ УЛИРЛААР (ҮНС ОРООГҮЙ)


→ % ЖИНГЭЭР



Шил болон **хуванцар** зуны улиралд өндөр буюу **53%** байсан бол өвлийн улиралд **35%** байв. Харин эсрэгээрээ хоол хүнсний хаягдал өвлийн улиралд илүү буюу **30%**, зуны улиралд зөвхөн **15%** байв.

7 ХОНОГТ ӨРХӨӨС ҮҮСЭХ ХОГ ДУНДАЖ ТӨРЛӨӨР

→ ӨРХ ТУС БҮР 7 ХОНОГТ ГРАММААР



Өвлийн улиралд **хүнсний хог хаягдал** зуны улиралтай харьцуулахад **хоёр дахин их** гарсныг өвлийн махны хэрэглээтэй холбоотой гэж үзэж байна. Яс зуны улирлын хүнсний хаягдлын дийлэнх болох ногооны хальстай харьцуулахад хүнд жинтэй.


Харин хүүхдийн живх голдуу ариун цэврийн хог хаягдал өвлийн улиралд мөн ихээр гарсныг зөвхөн тохиолдол гэж үзэж байна. Тус судалгаанд живх хэрэглэдэг насны хүүхэдтэй айл илүү оролцсон нь сумын төвийн бүх өрхүүдийг шууд төлөөлөх учиргүй.

ӨРХӨӨС 7 ХОНОГТ ҮҮСЭХ ХОГНЫ ХЭМЖЭЭ ДУНДЖААР

→ ӨРХ БҮР 7 ХОНОГТ КГ-ААР


Үнсийг оролцуулахгүйгээр нэг өрхөөс 7 хоногт дунджаар **3.5кг** хог үүсдэг ба энэ нь **нэг хүнд 0.9кг**, харин насанд хүрсэн хүн хүн тус бүрт **1.7кг** хог ноогдож байна.

Харин үнсийг оролцуулбал нэг өрх 7 хоногт дунджаар **5.8кг** хог үүсгэдэг бөгөөд **1.5кг**, харин насанд хүрсэн хүн тус бүрт **2.8кг** хог ноогдож байна.



НЭГ ХҮН ӨДӨРТ ҮҮСГЭХ ХОГНЫ ХЭМЖЭЭ ДУНДЖААР

→ ХҮН ТУС БҮРТ НЭГ ӨДӨРТ ГРАММАР




Үнсийг оролцуулахгүйгээр Хишиг-Өндөр сумын төвд амьдардаг нэг хүн өдөрт дунджаар 141гр хог үүсгэдэг байна. Үнсийг оролцуулбал 230гр. Үнсийг оролцуулалгүй тооцвол нэг хүнээс өдөрт үүсэх хогны хэмжээ жилийн туршид харьцангуй тогтвортой буюу 135-146гр байна.

- Үнсийг оруулаад
- Үнсийг орулцуулахгүйгээр

ӨРХИЙН ЖИЛИЙН ОРЛОГООС ХАМААРАН ӨРХӨӨС ҮҮСЭХ ХОГНЫ ХЭМЖЭЭ

→ ӨРХ ТУС БҮР 7 ХОНОГТ КГ-ААР (ҮНС ОРСОН)



Жилд 10сая төгрөгөөр дээш орлоготой өрхүүд үүнээс доош орлоготой өрхүүдээс арай бага хог үүсгэдэг нь ажиглагдсан. Гэхдээ энэ үр дүн нь зөвхөн зуны судалгааны үр дүн бөгөөд өвлийн судалгаагаар дахин батлагдаагүй болохыг анхаарна уу. Үүнийг цаашид нэмэлт судалгаагаар баталгаажуулах боломжтой.

ХУРААНГУЙ БОЛОН ДҮГНЭЛТҮҮД

- Ерөнхийдөө жилийн туршид, өрхөөс үүсэх нийт хогны **90%-ийг зөвхөн 5 үндсэн төрөл** эзэлж байна. Эдгээр нь: шил, хуванцар, хоол хүнсний хаягдал, үнс, хүүхдийн живх. Хоггүй сум болохын тулд орон нутгийн удирдлагууд эхний ээлжинд дээрх 5 төрлийн хогийг анхааран зохицуулах нь зүйтэй.
- Зуны улиралд өрхийн хог хаягдлын зөвхөн 11%-ийг үнс эзэлж байсан болон өвлийн улиралд хамгийн өндөр буюу 54%-ийг үнс эзэлж байна. Улирлаас хамааран гарах хэмжээ нь даруй 10 дахин их (0.4-4.3кг) байна.
- Зуны улиралд хийсэн судалгаанд (үнсийг оролцуулахгүйгээр) **шил болон хуванцар** өрхөөс үүсэх хог хаягдлын талаас илүү (**53%**) хувийг эзэлж байсан бол **өвлийн судалгаанд** зөвхөн гуравны нэг буюу **35%-ийг** эзэлж байна. Энэ бууралт нь мөн эцсийн жингийн хэмжээнд ч ажиглагдсан болно. (**зун 1.8кг, өвөл 1.3кг**)
- Зуны улиралтай харьцуулахад хүнсний хог хаягдал **өвлийн улиралд 2 дахин илүү** гардаг байна. Энэ үр дүн нь өвлийн улиралд хүмүүс мах ихээр хэрэглэдэгтэй холбоотой гэж бид үзэж байна. Махны өндөр хэрэглээ нь хүнд жинтэй яс ихээр үүсгэнэ.
- Жилийн туршид өрхөөс 7 хоногт гарах хогны дундаж хэмжээ ойролцоогоор үнсийг оролцуулбал 5.8кг харин үнсийг оролцуулахгүйгээр 3.5кг байна. Энэ нь хүн тус бүрт үнс оролцуулаад 230гр харин үнс оролцуулахгүйгээр 141гр хог хаягдал ноогдож байна. Үнсний хэмжээ улирлаас хамааран их ялгаатай байдаг ба үнсийг эс тооцвол өрхийн гишүүн тус бүрээс үүсэх хогны хэмжээ жилийн туршид харьцангуй тогтвортой байна.

НЭМЭЛТ ЗҮҮЛТ БОЛОН АНХААРАХ ЗҮЙЛС

- Зуны судалгааны үр дүнгээр өрхийн орлого нэмэгдэхийн хэрээр үүсэх хогны хэмжээ буурах хандлага илэрсэн. Гэвч энэ ажиглалт өвлийн судалгааны үр дүнгээр ахин батлагдаагүй. Тиймээс энэ хандлагыг нэмэлт ажиглалт, анализаар батлах эсвэл үгүйсгэх боломжтой.
- Байшинд амьдардаг болон гэрт амьдардаг өрхүүдээс үүсэх хогны хэмжээ, бүтцийн хувьд том ялгаа ажиглагдаагүй. Гэвч судалгаанд гэрт амьдардаг өрхүүд маш бага тоотой оролцсоныг дурдах хэрэгтэй. Цаашид зөвхөн гэрт амьдардаг өрхүүдийг сонгон судалгаа хийвэл сонирхолтой үр дүн гарч болох юм.
- Өвлийн судалгааны үр дүнгээс ариун цэврийн хог хаягдал харьцангуй их гарсан. Гэвч энэ нь зөвхөн тохиолдлын чанартай гэж үзэв. Учир нь өвлийн судалгаанд живх хэрэглэх насны хүүхэдтэй айлууд илүү оролцсон.
- Илүү өргөн цар хүрээгээр авч үзвэл өвөл болон зуны судалгаа зөвхөн нэг нэг долоо хоногийн хугацаанд хийгдсэн бөгөөд эдгээр судалгааны үр дүнд баяр ёслол болон бусад улирлын чанартай нөлөөлөх хүчин зүйлсийг оруулаагүй.
- Өвөл болон зуны судалгаанд зарим өрхүүд хоёуланд нь оролцсон ч дийлэнх өрхүүд өөрчлөгдсөн. Тиймээс түүвэрлэгдсэн өрхүүд хоёр судалгаанд өөр өөр байсныг дурдъя..
 - Хүн тус бүрт ноогдох хогны хэмжээг гаргасан ба үүнийг насны ялгаагүйгээр тооцсон болно.

